



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/441

Хэрлэн сум

“Галшар адууны баяр” эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9, 23.1.11 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас “Түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилтын хүрээнд зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгын дор соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, адуу дагасан их соёлын өв, адуучин эрсийн бахархалт өвийг хойч үед өвлүүлэн үлдээх зорилготойгоор иргэд, олон нийт, жуулчдад сурталчлан таниулах жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор “Галшар адууны баяр” эвент арга хэмжээг зохион байгуулах болсонтой холбогдуулан нэг жуулчин нэг унага арга хэмжээний зардлаас 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

